

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАНИЛЦУУЛГА**

/2024 оны жилийн эцсийн байдлаар/

Нэг. Хяналт- шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол шийдвэрийн нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр заасан хяналтад авсан зүйл, заалтуудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангахад оршино.

Хоёр. Арга зүй, ашигласан эх сурвалж

Хяналт-шинжилгээ үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгож, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудын хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээллийг үндэслэсэн болно.

Гурав. Үр дүн

Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол нийт 27 шийдвэрийн 35 заалт байна. Үүнд:

- 2023 онд хяналтанд авсан 9 шийдвэрийн 9 заалт;
- 2024 онд хяналтанд авсан 18 шийдвэрийн 26 заалт;

2024 оны жилийн эцсийн байдлаар 35 заалт бүрэн хэрэгжсэн бөгөөд биелэлтийг дараах байдлаар харуулбал:

- Монгол Улсын Засгийн газрын тогтоолын 15 шийдвэрийн 22 заалтаас 15 шийдвэрийн 22 заалт бүрэн хэрэгжиж 100 хувийн биелэлттэй;
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын 12 шийдвэрийн 13 заалтаас 12 шийдвэрийн 13 заалт бүрэн хэрэгжиж 100 хувийн биелэлттэй;

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг харуулбал:

Эрх зүйн акт	МУлсын Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	МУлсын ерөнхий сайдын албан даалгавар	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол	Бусад	Нийт
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		15			12		27

Үүнээс	Бүрэн хэрэгжсэн		15			12		27
	Хэрэгжих шатанд							
	Хасуулах саналтай							
	Тайлагнах хугацаа болоогүй							
Биелэлтийн хувь			100					100

Дөрөв. Дүгнэлт.

1. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” гэж үнэллээ.
2. Дээрх үнэлгээнээс үзэхэд Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай холбоотой гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа шуурхай хийгдэж байгаа нь ажлын явц, үр дүнгээс харагдаж байна.
3. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны “Тогтоол хүчингүй болгох тухай” тогтоолыг хяналтаас хасуулах саналтай байна.

Тав. Зөвлөмж.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг тухай бүр хяналтад авч бүртгэх, мөн зохион байгуулалтын нэгжийн дарга болон албан хаагчдад танилцуулж биелэлтийг журамд заасан хугацаанд Дотоод аудит, мониторингийн газарт ирүүлж байхыг зөвлөмж болгож байна.

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗАР